



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АРХАНГАЙ АЙМАГ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,  
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,  
Утас/Факс: (976) 7033 3141,  
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2024.08.08 № 345

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

Дүгнэлт хүргүүлэх тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.5, 37.10, Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд 2024 оны Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох Үнэн ба зөв намын сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

**Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл**

2024 оны Аймаг, сумын, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигч нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хууль, "Алсын хараа-2050" Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын талаарх тооцооны хамт ирүүлж, хуульд заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага нь 2024 оны Аймаг, сумын, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл болон бие даан нэр дэвшигчийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ MNS 6817-1:2020 Төрийн аудит, Тулгуур зарчим, Төрийн аудит, MNS 6817-6:2020 Төрийн аудит, Нийцлийн аудитын зарчим, Төрийн аудит, MNS 6817-8:2020 Төрийн аудит, Нийцлийн аудит стандартыг удирдлага болгон Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого, УИХ-аас баталсан хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны

650230525

төсвийн төсөөллийн тухай хууль, холбогдох бусад байгууллагаас авсан тайлан судалгаа мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

### Дүгнэлт

Үнэн ба зөв намын Аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны ээлжит сонгуульд оролцох мөрийн хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нь Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.3 дахь хэсэг, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

Үнэн ба зөв намын мөрийн хөтөлбөр (.....<sup>7</sup>..... хуудас)-ийг хавсаргав.

Хувийг: “Архангай аймгийн Сонгуулийн хороо”-нд

Хавсралт <sup>7</sup> хуудастай.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА



**ҮНЭН БА ЗӨВ НАМ**

# **ХҮЧТЭЙ СӨРӨГ ХҮЧИН**

ҮНЭН БА ЗӨВ НАМ-ын  
Архангай аймгийн ИТХ-ын  
сонгуулийн мөрийн хөтөлбөр


## ТӨРД ХЯНАЛТ ТҮМЭНД ИТГЭЛ...

### ТОВЧЛОЛ

Монгол Улсын өнгөрсөн 30 жилийн нийгэм, улс төрийн бодлого, амьдралд дүгнэлт хийж, 1990-2020 оныг хүртэлх УИХ 8 удаагийн, Ерөнхийлөгчийн 9 удаагийн, Орон нутгийн 8 удаагийн сонгуулиар ард түмэн, сонгогчдын сонголт, итгэл найдварыг зөвхөн өөрсдийн ЯЛАЛТ хэмээн ойлгож, МАНАН шударга ёсыг уландаа гишгэж, хууль гаргаж хулгай хийдэг авлигажсан, өрөнд орсон, ард түмэн нь ядуу өнөөгийн Монгол Улсыг бий болгосон байна.

Бид шударга ухаант ард түмний МАН, АН намуудын төр барих хугацааны үнэлэлт, дүгнэлт байнгын шүүмжлэлүүдтэй санал нэгдсэний үндсэн дээр 2017 онд Монгол Улсаа мандуулах гарц болгож Улс Төрийн жинхэнэ хүчин ҮНЭН БА ЗӨВ намыг байгуулсан болно.

МАНАН-г устгах нь чухал боловч МАНАН-ыг устгасны дараа Монгол Улсаа хүчирхэг болгож, ард түмнээ амар амгалан амьдруулах нь түүнээс чухал тул бид МОНГОЛ УЛСЫНХАА гурван цагийн хэлхээнд дүгнэлт хийж ард түмний хүлээлт, шаардлагад нийцсэн Улсаа засаж, хөгжүүлэх, үндсэн чиглэлийг дараах 5 бүлэгт багтаан гүйцэтгэхээр төлөвлөж буйгаа санал болгож байна. Бид хүчтэй улс төрийн хүчин байж төрд хяналт тогтоохоос гадна зөв зүйлийг дэмжиж хамтран ажиллах болно. Улс орон минь хөгжиж, ард түмэн жаргалтай амьдрах болтугай.



# ҮНЭН БА ЗӨВ НАМ УЛСАА ЗАСАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

Монголын ард түмэн бид:

- улсынхаа тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг бататган бэхжүүлж,
  - хүний эрх, эрх чөлөө, шударга ёс, үндэснийхээ эв нэгдлийг эрхэмлэн дээдэлж,
  - төрт ёс, түүх, соёлынхоо уламжлалыг нандигнан өвлөж,
  - хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэж,
- эх орондоо хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэм цогцлуулан хөгжүүлэхийг эрхэм зорилго болгоно гэсэн Монгол Улсын Үндсэн хуулийн зорилго дор сайн чигийг зөв заах ҮНЭН БА ЗӨВ НАМ-ын  
Архангай аймгийн ИТХ-ын сонгуулийн мөрийн хөтөлбөр

## НЭГДҮГЭЭР БҮЛЭГ ҮНДЭСНИЙ БАХАРХАЛ

**НЭГЭН ЗҮЙЛ:** Монголын ард түмний төлөө МАН, АН-ын хэзээ ч хийхгүй зүйлийг Монголын ард түмнийхээ төлөө ҮНЭН БА ЗӨВ НАМ дараах заалтуудаар хийнэ.

- 1.1 Монгол судлалыг хөгжүүлэхийг дэмжиж, дотоод, гадаадын судлаач, эрдэмтдийн судалгаа, аялал жуулчлалын шинжтэй аймгийн хэмжээнд болон бүс нутгийн хэмжээнд жил тутам зохион байгуулан, цаашид уламжлал болгоно.
- 1.2 Монгол түмний ондоошил болох нүүдлийн соёл иргэншлийг хадгалж, өвлүүлэхэд бүх талаар дэмжлэг үзүүлж, сурталчлах, таниулах бодлого баримтална.
- 1.3 Монгол бичгийн боловсролыг түгээн дэлгэрүүлэхэд анхаарч, монгол бичгэр хэвлэсэн ном, зохиолыг бүтээн, хөтөлбөр арга хэмжээг уялдаа, холбоотой зохион байгуулна.
- 1.4 Монголчуудын эв нэгдэл, эх оронч үзэл санааг төлөвшүүлэх ажлыг төр засгийн нэн тэргүүний ажил гэж үзнэ.
- 1.5 Монгол соён гэгээрэл, эрдэм мэдлэг, ёс суртахууныг нэгдсэн бодлого, хөтөлбөрийн цөм болгоно.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ БАДРАН ГИЙХ МОНГОЛ ХҮН

**НЭГЭН ЗҮЙЛ:** 1992-оос хойш АН, МАН-ын ард түмэнд амлаж мөрийн хөтөлбөртөө тусгаад хийгээгүй ард түмнийг хуурч мэхэлсэн сонгуулийн амлалтыг бүрийг бодит ажил болгохыг шаардаж нэхсэн сөрөг хүчин байх болно.

- 2.1 Ядуурал, ажилгүйдэл, тэгш бус байдлыг арилгах зорилгоор боловсролын хүртээмжийг сайжруулж, аз жаргалтай Монгол хүнийг бий болно.
- 2.2 Боловсрол /Мэдлэг + Чадвар + Хүмүүжил + Ёс зүй + Хариуцлага + Өв соёл+.../ ын ойлголтыг зөв тодорхойлж улс орноо хүчирхэг болгох зөв сэтгэлтэй иргэдийг бэлдэнэ.
- 2.3 Хүүхэд, өсвөр үеийнхнийг эх оронч үзлээр хүмүүжүүлэх, амьдрах ухаанд сургахад чиглэгдсэн ном зохиол, бүтээл туурвилыг төрөөс хөхүүлэн дэмжинэ.

- 2.4 Сургууль бүрд төрөл бүрийн клуб, дугуйлан хичээллүүлж, хүүхэд бүр 2-оос дээш дугуйлан, клубт хамрагдана.
- 2.5 Нэг хүүхдийн асуудлыг – Нэгдсэн сургалт”-ын хөтөлбөрт тусгах ажлыг санаачилж, хүүхэд бүрийн өөрийн оролцоонд тулгуурласан сургалтын орчин бүрдүүлнэ.
- 2.6 Цахим зайн сургалтын платформыг хөгжүүлэн, багш нарын оролцоог дэмжиж, цаг хугацаа, орон зайнаас үл хамааран суралцах боломжийг бүрдүүлнэ.
- 2.7 Насан туршийн боловсролын төвийг байгуулж, үйл ажиллагааг нь жигдрүүлэн өргөжүүлнэ.
- 2.8 Сургууль, цэцэрлэг, дотуур байруудыг цогцоор нь барина. Сургуулийн өргөтгөл барих, спорт заал барих, дулаан, цэвэр, бохир усны системд холбох ажлуудыг гүйцэтгэнэ.
- 2.9 Аймгийн төвд Олон улсын хөтөлбөртэй сургууль, цэцэрлэг, ясли байгуулна. Их дээд сургуулийн салбарыг байгуулна.
- 2.10 Иргэн бүрийг жилд нэг удаа эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт заавал хамруулна. Монгол хүний дундаж наслалтыг 75 насанд хүргэх эрүүл, аюулгүй, аз жаргалтай нийгмийг бүтээнэ.
- 2.11 Сум дундын түргэн тусламжийн төвийн материаллаг баазыг сайжруулж, шаардлагатай эмчилгээний хөдөлгөөнт тоног төхөөрөмжөөр хангана.
- 2.12 Нийтийн биеийн тамирыг дэмжиж, эрүүл идэвхтэй амьдралын хэв маягийг хөгжүүлнэ.
- 2.13 Иргэдэд үйлчлэх спортын зориулалтын стандарт талбайн хүртээмжийг нэмэгдүүлнэ.
- 2.14 Шинжлэх ухаанд суурилсан, шинжлэх ухааны бүтээлийг олон улсад таниулж, иргэн төвтэй үнэ цэнийг бий болгоно.
- 2.15 Монгол анагаах ухааныг дэлхийн брэнд болгож, анагаах ухааны мэдлэг, судалгааны ажил, уламжлалт эмийг экспортолно.
- 2.16 Өндөр технологи, нано-технологич, инновацын бүтээлийг бодлогоор дэмжинэ.
- 2.17 Судалгаа, шинжилгээ, шинэ санаа, оюуны бүтээл, брэндэд тулгуурласан, гадаад зах зээлд чиглэсэн үйлдвэрлэлийг дэмжинэ.
- 2.18 Аймгийн иргэд аймаг, орон нутагтаа ажиллаж хөдөлмөрлөх таатай орчин бий болгоно.
- 2.19 Орчны бохирдлыг үе шаттайгаар багасгаж, цэвэр ногоон байгууламж бүхий орчныг нэмэгдүүлнэ.
- 2.20 Аймгийн төвийн үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах, шугам сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ.
- 2.21 Айл өрхийг цэвэр бохир усны төвлөрсөн шугамд үе шаттайгаар холбож, сайжруулсан ариун цэврийн байгууламжийн тоог нэмэгдүүлнэ.
- 2.22 Эмэгтэйчүүдийг хүчирхэг, эдийн засаг, санхүүгийн хараат бус, аз жаргалтай амьдрах бүх нөхцөлийг бүрдүүлнэ.
- 2.23 Залуучуудыг гадны өндөр хөгжилтэй улсад сурч, ажиллах нөхцөл боломжоор хангах ажлыг зохион байгуулна.

- 2.24 Ажилгүйдлийг бууруулах, ажлын байрыг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлнэ. Албан бус хөдөлмөр эрхлэлтийн бүртгэл, мэдээллийг сайжруулна.
- 2.25 Хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настанд ээлтэй, хүртээмжтэй орчин нөхцөлийг бүрдүүлж, хөдөлмөр эрхлэх боломжоор хангана.


## ГУРАВДУГААР БҮЛЭГ АЧЛАЛТ ТӨР - ЗАСАГЛАЛ

### НЭГЭН ЗҮЙЛ. "АМАР АМГАЛАН АЖ АМЬДРАЛ"

- 3.1 Иргэдийн эх орноо хөгжүүлэх, ажил хэрэгч саналыг дэмжиж ажиллана.
- 3.2 Иргэн та асуудал дэвшүүлж, хүсэлтээ бидэнд гаргах юм бол бид тэр санал хүсэлтийг шийдвэрлэх хүртэл нэхэж ажилладаг хариуцлагатай улстөрийн хүчин байна.
- 3.3 Сум багуудыг интернэт сүлжээнд холбоно.
- 3.4 Дотоод удирдлагын ERP системийг нэвтрүүлэн тусгай зөвшөөрөл, өргөдөл гомдол, санал хүсэлтийг цахимаар хүлээн авч, шийдвэрлэнэ.
- 3.5 Чадварлаг боловсон хүчин төрийн албан хаагчдын ажлын байрыг баталгаажуулна.
- 3.6 Төрийн албыг цомхон, чадварлаг, хариуцлагатай, ёс зүйтэй ажилладаг болгон шинэчилнэ. Төрийн албан хаагч улс төрийн нөлөөллөөс болж ажлаас халдаг байдлыг бүрэн зогсооно.
- 3.7 Төрийн албан хаагчдыг шилж сонгох, мэргэжил ур чадварыг нь дээшлүүлэх, идэвхжүүлэх тогтолцоог төгөлдөржүүлнэ.
- 3.8 Монголын төрөөс хулгай хийсэн, авлига авсан, гадны эрх ашигт үйлчилсэн хүнийг 3 үеэр нь Монголын төрд ажиллуулахгүй байх эрх зүйн орчин бүрдүүлэх зорилгоор хуулийн төсөл өргөн барина.
- 3.9 Байгалийн баялаг, иргэдийн боломжийг дээрэмдэж хөрөнгөжсөн хүмүүст хөрөнгийн эх үүсвэрээ нотлох шалгалт оруулан, зохих шатны хууль хяналтын байгууллагад шилжүүлж ажиллана.
- 3.10 Эрүүл мэндийн салбар дахь эрх мэдэлтнүүдийн нөлөөллийг арилгаж, шударга тогтолцоог бүрдүүлнэ.
- 3.11 Нийгмийн халамжийн зорилтот бүлэгт хүрч халамжийн үйлчилгээг ил тод, нээлттэй, чирэгдэлгүй хүргэнэ.
- 3.12 Хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдал, хяналтыг сайжруулна.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ НЭГЭН ЗҮЙЛ: НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

- 4.1 Булаг шандны эхийг хамгаалж, тохижуулах ажлыг үргэлжлүүлэн, хөв цөөрөм байгуулна.
- 4.2 Эвдрэлд орж, доройтсон газрыг нөхөн сэргээн, хог хаягдал бүхий талбайг үе шаттайгаар бууруулна.




- 4.3 Нэн ховор, ховор амьтан, ургамлын нөөц, ховордсон зүйлийг хамгаалж, нөхөн сэргээн нутагшуулахад анхаарна.
- 4.4 Гол мөрөн, ойн санг хамгаалах ажлын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана. Мод тарих, бэлчээрийг нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх хөтөлбөрийг дэмжинэ.
- 4.5 Гамшигтай тэмцэх үйл ажиллагааг боловсронгуй болгон засаг захиргааны нэгж, бүс нутгийн чадварыг сайжруулна.

**ТАВДУГААР БҮЛЭГ**  
**НЭГЭН ЗҮЙЛ: ЭДИЙН ЗАСАГ, ДЭД БҮТЦИЙН ХӨГЖЛИЙН**  
**БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

- 5.1 Байгалийн баялагт түшиглэж, боловсруулах үйлдвэр барина.
- 5.2 Дулааны цахилгаан станцын барилгын ажлыг эрчимжүүлнэ.
- 5.3 Малчдын талаар төрөөс баримталж буй бодлогын шинэчлэлийг санаачилж, малчдын нийгэм, эрүүл мэндийн баталгааг сайжруулна.
- 5.4 Малын тоо толгойд бус, чанарт анхаарсанаар бэлчээрийн даац хэтрэлтийг зохистой шийдвэрлэнэ.
- 5.5 Мал аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний боловсруулалтыг нэмэгдүүлж, экспортыг дэмжинэ.
- 5.6 Аймгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, худалдааны үр ашгийг дээшлүүлэх, дотоод, гадаадын хөрөнгө оруулалтыг чиглүүлэх, тогтвортой хөгжлийг хангахад гадаад харилцаа, хамтын ажиллагааг эрчимжүүлнэ.
- 5.7 Байгальд ээлтэй, бэлчээрийн мал аж ахуй, зэрлэг ан амьтанд ээлтэй дэд бүтцүүдийг төлөвлөн, эрх барих дээд байгууллагат өргөн барьж, шийдвэрлүүлнэ.
- 5.8 Орон нутгийн аялал жуулчлалын байгууллагуудын чадавхийг дээшлүүлж, орлогыг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

**ЗУРГААДУГААР БҮЛЭГ**  
**НЭГЭН ЗҮЙЛ: БҮСЧИЛСЭН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД**

- 6.1 Дэлхий дахины болон бүс нутгийн улс төр, эдийн засгийн хамтын ажиллагаанд харилцан ашигтай байх зарчмыг баримтлан идэвхтэй оролцоно.
- 6.2 Дотоод, гадаадын жуулчдад зориулсан аялал жуулчлалын зурвасуудыг ая тохьтой хөгжүүлж, хувийн хэвшлээр дамжуулан аймгийн төсвийн орлогыг нэмэгдүүлнэ.



**ДОЛДУГААР БҮЛЭГ**  
**НЭГЭН ЗҮЙЛ: АМАР ТАЙВАН АМЬДРАЛЫН ҮНДЭС**

- 7.1 Аймгийн нийт иргэдийн аюулгүй байдлыг хангах үүднээс хүчний байгууллагын шуурхай байдлыг дээшлүүлнэ. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэлтийг ухуулан таниулах арга хэмжээг дэмжинэ.
- 7.2 Цэрэг, цагдаагийн байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлж, хүний нөөцийн чадавхийг нэмэгдүүлнэ.
- 7.3 Мэдээллийн аюулгүй байдлыг сайжруулахад олон улсын төсөл хөтөлбөрүүдийг чиглүүлнэ.
- 7.4 Хүүхэд хамгааллын үйлчилгээг сайжруулж, хүүхдийн эрхийг дээдлэн, аливаа хэлбэрийн хүчирхийлэл, дарамт шахалт, хөдөлмөрийн мөлжлөгөөс ангид байлгаж, хэрэгжилтэд хяналт тавина.
- 7.5 Гадаад орнуудын хамтын ажиллагааг зохих шатанд дэмжиж ажиллахдаа үндэсний аюулгүй байдал, ард түмний язгуур эрх ашгийн үүднээс зохистой тэнцвэрийг хадгалах бодлого явуулна.

**ҮНЭН ЯЛНА ҮР ҮЛДЭНЭ...**

